



Микрокредит ББСБ ХХК-ийн Хувцаа эзэмшигчдийн
2022 оны 08 сарын 29-ны өдрийн 22/04
Тогтоолын Хавсралт№1

“МИКРО КРЕДИТ ББСБ” ХХК-ИЙН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ

Улаанбаатар хот

2022 он

АГУУЛГА

1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

2 дугаар зүйл. Үндсэн чиглэл

3 дугаар зүйл. Дотоод хяналт шалгалт явуулах ажилтны эрх үүрэг

4 дүгээр зүйл. Хяналт шалгалтын хэлбэр

5 дугаар зүйл. Хүлээх хариуцлага, Урамшуулал үзүүлэх

6 дугаар зүйл. Бусад

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журам нь Микро кредит ББСБ –ын Дотоод хяналт шалгалтын ажилтны эрх, үүрэг, хариуцлага, түүний үйл ажиллагаа гүйцэтгэх ажил үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Хяналтын зорилго нь ББСБ –ын тухай хууль “Микрокредит” ББСБ –ын дүрэм, Гүйцэтгэх захирлын шийдвэрийн хэрэгжилт, төлбөр тооцоо, бүртгэлийг эрх бүхий байгууллагаас баталсан бүртгэл тооцооны стандартын дагуу үнэн зөв хөтөлж буй эсэх, мөнгөн хөрөнгө, үнэт зүйлсийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, түүний үр ашиг, үүргийн биелэлт, дотоод хяналт шалгалтын ажилтан бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.3. Дотоод хяналтын шалгалтын ажилтан нь үйл ажиллагаандаа банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад хууль тогтоомж, заавар журмуудыг мөрдлөг болгон ажиллана.

ХОЁР. ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- 2.1. Энэхүү журмын 1.3 –т заасан хууль тогтоомжуудын хэрэгжилт, “Микро кредит” ББСБ –ын дүрэм болон Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэрийн биелэлт, түүний үр дүн.
- 2.2. “Микро кредит” ББСБ –ын салбар нэгжүүд өөрийн үүрэг зорилтыг биелүүлж, үйл ажиллагаагаа зөв уялдуулж байгаа эсэх.
- 2.3. “Микро кредит” ББСБ –ын гадаад валютын нөөцийн удирдлага, мөнгө, үнэт цаас, валютын арилжааны үйл ажиллагаанд тавивал зохих дотоод хяналтын тогтолцоо.
- 2.4. “Микро кредит” ББСБ –ын бүх төрлийн актив, үүний дотор авлага, мөнгөн тэмдэгт, үнэт зүйл, эд хөрөнгийн чанар бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт түүний бүртгэл тооцоо, тооллого.
- 2.5. Гадаад, дотоодын харилцагч банк, байгууллагуудтай хийсэн гэрээ хэлцэл хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байдал түүний хэрэгжилт.
- 2.6. “Микро кредит” ББСБ –ын гүйлгээний орлого, зарлагын зүйл ангийн бүрдлийн үнэн зөв байдал, тайлант жилийн ашгийн хуваарилалт, сангуудын хөдөлгөөнийг зохих шийдвэрийн дагуу хийж байгаа байдал, найдваргүй зээлийн нөөцийн сангийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалтын байдал, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дансны хөдөлгөөний бүртгэл зэрэг нь үндсэн баримттайгаа тохирч, гарсан тушаал шийдвэр байгуулсан гэрээтэй нийцэж буй эсэх.
- 2.7. Сар, улирал, жилийн тайлан тэнцэл, мэдээ, судалгаа нь хугацаандаа үнэн зөв гарсан эсэх.
- 2.8. Зээлийн хувийн хэргийн бүрдэлт, зээлийн барьцаа болон баталгааг хуулийн хүчин төгөлдөр баримтаар гаргасан байдал, зээл, түүний хүүгийн төлөлтийн байдал.

ГУРАВ. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ

А. ҮҮРЭГ

- 3.1. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь “Микрокредит” ББСБ –д учирч болох эрсдэлийг олж тогтоох, засаж залруулах, сэрэмжлүүлэх зорилгын үүднээс ББСБ-ын үйл ажиллагааг шалгах эрхтэй байна.
- 3.2. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт судалгаа, дүгнэлт хийх хэлбэрээр банк бус санхүүгийн байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлыг шаардлагатай мэдээллээр хангана.
- 3.3. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь “Микрокредит” ББСБ –ын Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захиралд ажлаа тайлагнаж танилцуулна.

- 3.4. Хэрэгжүүлж байгаа хяналтын ажил нь Гүйцэтгэх захирлын баталсан зорилт, шийдвэрийг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчилтэй зүйлд анхаарлаа хандуулж холбогдох арга хэмжээ авах.
- 3.5. Хяналт шалгалтыг явуулж акт, танилцуулгыг үйлдэн Гүйцэтгэх захиралд тайлагнаж “Микрокредит” ББСБ –ын ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.
- 3.6. Үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх, үнэнч шударга, боловсон ажиллах, мэдээллийн нууцыг чандлан хадгалах буюу өөрийн хувийн сонирхолд ашиглахгүй байх зарчмыг баримтлах.
- 3.7. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаанд итгэх итгэлийг бий болгож, түүнийг бэхжүүлэх талаар санаачлагатай ажиллах.
- 3.8. Хяналт шалгалтын талаарх танилцуулга, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бүрэн дүүрэн, цогцоор нь бүрдүүлэн үйлдэж, тодорхой акт материалаар баталгаажуулсан байх.
- 3.9. Хяналт шалгалтын акт материалыг шалгуулагчдад танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулна. Хэрэв шалгуулагч гарын үсэг зурахаас татгалзвал, татгалзсан тухай үндэслэлийг бичүүлж шалгалтын материалд хавсаргах.
- 3.10. Хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, акт, тоо баримтын үндэслэл нотолгооны үнэн зөвийг хариуцах.
- 3.11. Хяналт шалгалтын ажлын хүрээнд танилцсан, мэдсэн байгууллагын тухай болон хяналт шалгалтын ажлын мэдээлэл, тоо бүртгэл, баримт бичгийг санаатай болон санамсар болгоомжгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй, мэдээлэхгүй, ашиглуулахгүй байх.

Б. ЭРХ

- 3.12. “Микрокредит” ББСБ - ын актив, үүний дотор авлага, мөнгөн тэмдэгт, үнэт зүйлс, үндсэн хөрөнгө, материалд тооллого хийлгэж, тооцоо бодуулах.
- 3.13. Хууль тогтоомж зөрчин улс, байгууллага, иргэдэд учруулсан хохирол, төлөгдөөгүй төлбөрт акт тогтоон төлүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох талаар холбогдох албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулж харуй авах. Хэрэв биелүүлэхгүй бол удирдах албан тушаалтанд танилцуулж холбогдох арга хэмжээг авхуулах.
- 3.14. Хяналт шалгалтын талаархи танилцуулга, тайланд шаардагдах мэдээ судалгаа, тайлбар тодорхойлолт бусад баримт бичгийг албан тушаалтнаас гаргуулах.
- 3.15. “Микрокредит” ББСБ –ын албан тушаалтны үйл ажиллагаа зохих хууль тогтоомжийг зөрчсөн эсэхийг магадлан шалгаж, дутагдлыг засаж залруулах, хариуцлага тооцох шаардлагатай гэж үзвэл Гүйцэтгэх захиралд танилцуулж шийдвэрлүүлэх.
- 3.16. Шалгалтын үр дүнд дүгнэлт хийж, заавар зөвлөмж өгөх.

ДӨРӨВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛБЭР

- 4.1. Бүрэн хэмжээний шалгалт. Энэ нь санхүүгийн нэг жилийн хугацааг хамруулан нягтлан бодох бүртгэлийн үндсэн баримтыг тэнцлийн гүйлгээ бүртэй нэг бүрчлэн тулган шалгана.
- 4.2. Сонгон шалгалт. Энэ нь ТУЗ-ын тогтоолоор болон Гүйцэтгэх захирлын тушаалаар өгсөн үүргийн дагуу хязгаарлагдмал хэсгийг сонгон шалгах бөгөөд гол төлөв батлагдсан хуваариас гадна хийгдэнэ.
- 4.3. Жилд 4 удаа гэнэтийн шалгалтыг хийж болно.

ТАВ. ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ, УРАМШУУЛАЛ ҮЗҮҮЛЭХ

- 5.1. Дотоод хяналт шалгалтын ажилтны тогтоосон акт, шаардлагыг “Микрокредит” ББСБ-ын албан тушаалтан, тогтоосон хугацаанд биелүүлж, энэ тухай хариуг албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.
- 5.2. Шалгуулагч тогтоосон акт, баримт нь үндэслэлгүй гэж үзвэл тайлбар бичиж гарын үсэг зураад дахин шалгуулах гомдол гаргах эрхтэй. Энэхүү гомдол гаргасан тохиолдолд Гүйцэтгэх захирал дахин өөр байцаагч түр томилон гомдлыг шалгуулах эрхтэй. Гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.
- 5.3. Дотоод хяналт шалгалтын ажилтныг албан үүргээ гүйцэтгэж байхад нь албан шаардлагыг эсэргүүцсэн, үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагыг биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг ирүүлээгүй, хяналт шалгалтанд саад учруулсан ажилтан, албан тушаалтанд хариуцлага тооцно.

ЗУРГАА. БУСАД

- 6.1. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн, энэхүү журмыг биелүүлээгүй бол түүнд холбогдох хууль тогтоомж болон Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 6.2. Дотоод хяналт шалгалтын ажилтны ажлын хөлсийг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр тухай бүр нь олгоно.